



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2004 оны 7 сарын 26 өдөр

Дугаар 244

Улаанбаатар

Гадаадад суралцуулах тухай

“Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс”-ын 2004 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын 2.6-г үндэслэн ТУШААХ нь:

1. Цэвэгмид овогтой Эрдэмбилэгийг Италийн Ром хотын Тор Вергата их сургуулийн магистрантурт анагаах ухааны чиглэлээр, Цэгмид овогтой Цэндпүрэвийг Англи улсын Лийдс хотын Метрополитаний их сургуулийн магистрантурт орчин үеийн урлагийн чиглэлээр, Сандаг овогтой Өлзийхутагийг мөн сургуулийн магистрантурт санхүү-эдийн засгийн мэргэжлээр, Баярмагнай овогтой Баясгаланг АНУ-ын Денвер хот дахь Колорадоийн Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Батжаргал овогтой Заяабалыг АНУ-ын Калифорны их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Очир овогтой Эрдэнэгэрэлийг Канад улсын Калгарын их сургуулийн магистрантурт эдийн засгийн чиглэлээр, Цэнд овогтой Содхүүг АНУ-ын Калифорны их сургуулийн магистрантурт эдийн засаг, бизнесийн удирдлагын чиглэлээр, Дашидондов овогтой Баярсайханыг Шинэ зеланд улсын Крайсчөрч хотын Кантенбури их сургуулийн магистрантурт иргэний эрх зүйн чиглэлээр, Батнасан овогтой Мөнхжаргалыг Шинэ зеланд улсын Крайсчөрч хотын Кантенбури их сургуулийн магистрантурт үл хөдлөх хөрөнгийн барьцааны зохицуулалтын чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2004-2005 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. 2004-2005 оны хичээлийн жилээс эхлэн ОХУ-ын Дотоод явдлын яамны Удирдлагын академид 2 жилийн хугацаагаар суралцах Лувсанцэрэн овогтой Ганбаатар, Нямдорж овогтой Нямцэвээн, Дорж овогтой Сундуйсүрэн, ОХУ-ын Дотоод явдлын яамны Санкт-Петербург хот дахь их сургуулийн докторантурт 3 жилийн хугацаагаар суралцах Думбарай овогтой Мягмарцэрэн нарын жилийн сургалтын төлбөрийн зээлийн хэмжээг хүн тус бүрд 6000 ам.доллараар, ОХУ-ын Хууль зүйн яамны дэргэдэх Рязань хот дахь Эрх зүй, удирдлагын академид 2 жилийн хугацаагаар суралцах Чойжанцан овогтой Болдбаатар, Баатар овогтой Лхагвасүрэн нарын жилийн сургалтын төлбөрийн зээлийн хэмжээг тус бүрд 2782 ам.доллараар, ОХУ-ын Онц байдлын яамны Гал эсэргүүцэх улсын албаны академийн магистрантурт 3 жилийн хугацаагаар суралцаж байгаа Дорждэрэм овогтой Бэхбаяр, Ганхуяг овогтой Ганбаатар, Дамжин овогтой Баян-Эрдэнэ нарын

сүүлийн 2 жилийн сургалтын төлбөрийн зээлийн жилийн хэмжээг хүн тус бүрд 1800.0 ам.доллараар тус тус тогтоосугай.

3. АНУ-ын Де Врай их сургуулийн Чикаго дахь салбар сургуульд бизнесийн удирдлагын чиглэлээр элсэн Г.Бодьбилигүүн, АНУ-ын Денвер хот дахь Колорадогийн их сургуульд элсэн П.Нансал нарт 2 жилийн, Австрали улсын Сиднейн их сургуулийн Дүрслэх урлагийн сургуулийн уран зургийн ангид суралцаж байгаа Хүрэлбаатар овогтой Хоснаранд нэг жилийн сургалтын төлбөрийн зээл олгосугай.

4. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасурэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



САЙД

А ЦАНЖИД